

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга,
нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт


Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр: **Аймгийн Засаг дарга**

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2023.09.29	A/499	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2023.09.29	A/500	Хөрөнгө зарцуулах тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: **Б.Гантулга**



Холбогдох утас: 70384096, 88089938
И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/499

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.3.9, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XVI хуралдааны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хоггүй Хөвсгөл төслийн хүрээнд “Хог биш баялаг НҮТББ”-аас хог хаягдлын чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг иргэд, аж ахуй нэгж байгууллага, бизнес эрхлэгчид, сургуулийн сурагчдад сургалт нөлөөллийн ажлыг танхимаар болон цахимаар зохион байгуулах зардалд 2.600.000 (хоёр сая зургаан зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 2.600.000 (хоёр сая зургаан зуун мянган) төгрөгийг Засаг дарга дансны “Хоггүй Хөвсгөл арга хэмжээний хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны зардал”-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/500

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын багш нарын өдрийн үйл ажиллагааны зардалд 3,000,000 (Гурван сая), Мөрөн сумын Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн 100 жилийн ойг тохиолдуулан тус сургуулийн багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаанд 6,000,000 (Зургаан сая) төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 9,000,000 (Есөн сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардал"-аас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх), нягтлан бодогч (Д.Балжинням) нарт зөвшөөрсүгэй.

3. Монголын багш нарын өдрийн үйл ажиллагааны зардлын дэмжлэг 3,000,000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дансанд, багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны дэмжлэг 6,000,000 (Зургаан сая) төгрөгийг Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн дансанд тус тус шилжүүлэхийг нягтлан бодогч (Д.Балжинням)-д даалгасугай.

4. Дэмжлэгээр олгосон хөрөнгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн зориулалтын дагуу зарцуулахыг Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ш.Отгон-Эрдэнэ), Дэлгэрмөрөн цогцолбор сургуулийн захирал (Б.Гантулга) нарт үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

